
monlogistics
GROUP
2026
III УЛИРЛЫН ТАЙЛАН
MSE:MLG
www.mlholding.mn
Image generated by AI



monlogistics GROUP

About the Company

Монложистикс Групп нь 2005 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 7 охин компани, 180 гаруй ажилтан, дэлхийн 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол Улсын тээвэр логистикийн салбарын тэргүүлэгч групп компани болсон байна. Монложистикс Групп нь Монгол Улсын эдийн засгийн чухал салбар болох тээвэр логистикийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, иргэдийн өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уурхайн түүхий эдийг экспортлох, хөрш болон гуравдагч орнуудыг ачаа тээвээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг, карго зэрэг тээвэр логистикийн бүх төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн үзүүлсээр байна.

Өнгөрсөн 20 жилийн турш бид харилцагч, ажилтнууд, түншүүдийнхээ итгэл дээр тулгуурлан, инновац, чанар, хариуцлагыг эрхэмлэж ажиллаж ирсэн бөгөөд эдүгээ бизнесийн тогтвортой өсөлт, менежментийн шилдэг туршлага, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараараа тээвэр логистикийн салбартаа тэргүүлэгч групп компани болжээ.

Монложистикс Холдинг ХК нь группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, тэдгээрт хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, маркетинг, стратеги ба бизнес хөгжил, ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг толгой компани юм.


Дэлхий рүү тэмүүлэх
Үндэсний брэнд
Image generated by AI

Эрхэм зорилго

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Алсын хараа

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.



Image generated by AI

Үнэт зүйлс

Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтээл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.

Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинэийг санаачлагч багуудаас бүрдэнэ.

Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол Улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.

Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараараа цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.

Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.



Image generated by AI

Группийн түүхэн замнал

2005 ОН

Монложистикс Ворлдвайд ХХК анхны ууган компани байгуулагдав.

2006 ОН

Монголын Тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2009 ОН

Төмөр замын аюулгүй ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүлээн авав.

2010 ОН

Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас Гаалийн зуучлагчийн тусгай зөвшөөрлийг авав.

2011 ОН

Монголын гаалийн зуучлагчдын нэгдсэн холбооны гишүүнээр элсэв.

2014 ОН


Олон улсын тээвэр зуучийн нэгдсэн холбоонд албан ёсны гишүүнээр элсэв.

2015 ОН

ISO 9001:2008 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэв.

2016 ОН

Rebranding **“Upgrade 10”** төслийг амжилттай эхлүүлэв.



2017 ОН

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.

МАНДАЛ ДААТГАЛ

2018 ОН

Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.

2019 ОН

Монложистикс Транзит ХХК байгуулагдав.

2020 ОН

Монложистикс Холдинг ХХК Толгой компани байгуулагдав.

2021 ОН

Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.

2022 ОН

Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Каус Аустралис ХХК-ийг байгуулав.

2023 ОН

Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.

IPO

2024 ОН

Группт Төв Азийн Зам ХХК нэмэгдэв. CORE системийн шинэчлэл хийгдэв.

2025 ОН

Монложистикс групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой тохиолоо.




Image generated by AI

Группийн бүтэц



Онцлох үйл явдал



Хүнд даацын цахилгаан тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх хамтын ажиллагааг эхлүүллээ.

Монложистикс Групп ногоон хөгжлийн бодлогын хүрээнд “Эм Эм Эс Инженеринг” ХХК-тай хамтарсан компани байгуулах санамж бичигт гарын үсэг зурлаа. Хоёр тал Монголын анхны өндөр хүчин чадлын цахилгаан тээврийн цэнэглэх станцыг сэргээгдэх эрчим хүч, батарей хуримтлуурын системтэйгээр хамтран хөгжүүлнэ.



Нээлттэй зах зээл дээрээс хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг эхлүүллээ.

Монложистикс Холдинг ХК (MSE:MLG) нь хөрөнгийн зах зээлийн нөхцөл, компанийн санхүүгийн чадавх, хувьцааны үнэлгээнд үндэслэн нийт 7.14 сая ширхэг хувьцаагаа нэгж бүрийг нь ₮210 (Эргүүлэн худалдан авах захиалгын дээд үнэ) хүртэлх үнээр нээлттэй зах зээл дээрээс эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг дахин хэрэгжүүлэх гэж байна. Хувьцаа эргүүлэн худалдан авалт нь 2026.09.01- 2027.12.31-ний өдрийг дуустал үргэлжилнэ.



“LOGISTICS: ДЭЛХИЙ РУУ ТЭМҮҮЛСЭН ОН ЖИЛҮҮД” номыг эрхлэн гаргалаа.

Монложистикс Групп үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойдоо зориулан Непко хэвлэлийн газартай хамтран “LOGISTICS: ДЭЛХИЙ РУУ ТЭМҮҮЛСЭН ОН ЖИЛҮҮД” номыг эрхлэн гаргаж, уншигчдын хүртээл болголоо. Тээвэр, ложистикийн салбарын хөгжил, онцлог, түүхэн замналын талаарх өргөн хүрээний мэдлэг, мэдээллийг багтаасан тус бүтээл нь салбарын мэргэжилтнүүд, энэ чиглэлээр суралцаж буй оюутан, залуучууд болон ложистикийн талаар мэдлэгээ тэлэхийг хүссэн хэн бүхэнд зориулагдсан юм.

Онцлох тээвэр




115 тоннын уурхайн тоног төхөөрөмжийн тээвэр

Гуравдугаар улиралд тус бүр 115 тонн жинтэй уурхайн хүдэр бутлах, нунтаглах төхөөрөмжүүдийг Герман улсаас Монгол Улс руу амжилттай тээвэрлэлээ. Хүнд жинтэй ачааны онцлогт нийцүүлэн тээвэрлэлтийг нарийн төлөвлөж, аюулгүй ажиллагааг ханган зохион байгууллаа.



Эрчим хүч хуримтлуулах системийн тоног төхөөрөмжийн тээвэр

50 МВт чадал, 200 МВт·ц эрчим хүчний багтаамжтай батарейд суурилсан эрчим хүч хуримтлуулах системийн трансформаторын тоног төхөөрөмжийг БНХАУ-аас Монгол Улс руу тээвэрлэлээ. Төслийн тоног төхөөрөмжийн онцлогт тохируулан тээвэрлэлтийн үе шат бүрийг уялдуулж, амжилттай гүйцэтгэлээ.



Аюултай ачааны чартер нислэг

БНСУ-аас Улаанбаатар хот руу аюултай ачаа тээвэрлэх хоёр удаагийн чартер нислэгийг мөн энэ гуравдугаар улиралд амжилттай зохион байгууллаа. Тусгай нөхцөл шаардсан ачааны тээвэрлэлтийн бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, нислэгүүдийг аюулгүй гүйцэтгэлээ.

Үйл ажиллагааны тайлан

- Тээврийн салбарын нийт орлого
- Монложистикс Группийн орлого
- Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ
- Монложистикс Группийн ачааны хэмжээ



Image generated by AI


monlogistics GROUP



Image generated by AI


МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО

/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




2026 оны III улирлын байдлаар Монложистикс Группийн орлого 267.6 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс +24% өссөн байна.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / САЯ ТОННООР /



2026 оны III улирлын байдлаар Монгол Улсын нийт ачаа тээврийн хэмжээ 137.5 сая тонн хүрч, өмнөх оны мөн үеэс 35.1%-иар өссөн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /




Монложистикс Группийн нийт ачаа тээврийн хэмжээ 658 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 8.4%-иар өссөн байна.

ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНГОЛ УЛС


/ САЯ ТОННООР /



Монгол Улсын экспортын ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 33.5%-иар өсөж, 97.0 сая тоннд хүрсэн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУПП

/ МЯНГАН ТОННООР /




Монложистикс Группийн экспортын ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 67.8%-иар буурч, 9.6 мянган тоннд хүрсэн байна.

ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНГОЛ УЛС


/ САЯ ТОННООР /



Монгол Улсын импортын ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.9%-иар өсөж, 7.1 сая тоннд хүрсэн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУПП

/ МЯНГАН ТОННООР /




Монложистикс Группийн импортын ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 18.3%-иар өсөж, 118.4 мянган тоннд хүрсэн байна.

ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНГОЛ УЛС


/ САЯ ТОННООР /



Монгол Улсаар дамжин өнгөрөх транзит ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.7%-иар буурч, 4.3 сая тоннд хүрсэн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУПП

/ МЯНГАН ТОННООР /




Монложистикс Группийн зохион байгуулсан транзит ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7.8%-иар өсөж, 508.3 мянган тоннд хүрсэн байна.

ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНЛОЖИСТИКС ГРУПП

/ МЯНГАН ТОННООР /



Монложистикс Группийн гадаад улс доторх ачаа тээврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 297.2%-иар өсөж, 21.7 мянган тоннд хүрсэн байна.

НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2024 Q3	2025 Q3	2026 Q3
Борлуулалтын орлого	224,155	216,467	267,601
Борлуулалтын өртөг	(205,952)	(197,374)	(246,433)
Нийт ашиг	**18,203**	**19,093**	**21,168**
Борлуулалт, Удирдлагын зардал	(6,741)	(8,081)	(7,718)
Бусад орлого (зардал)	917	1,643	44
Үйл ажиллагааны цэвэр ашиг	**12,380**	**12,655**	**13,494**
Санхүүгийн орлого (зардал)	(1,338)	(1,899)	206
Татварын өмнөх цэвэр ашиг (EBT)	**11,042**	**10,756**	**13,700**
ОАТ-н зардал	(986)	(1,230)	(1,303)
Татварын дараах цэвэр ашиг	**10,056**	**9,526**	**12,397**
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	597	597	
Цэвэр ашиг	**10,056**	**10,123**	**12,397**
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	7,494	7,312	9,371
Хяналтын эрхгүй хувь оролцоо	2,562	2,213	3,026
Бүх дэлгэрэнгүй орлого			
Бусад дэлгэрэнгүй орлого		2,034	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	(133)	270	(164)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	**9,923**	**11,829**	**12,233**
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	7,361	9,019	9,208
Хяналтын эрхгүй хувь оролцоо	2,562	2,213	3,026
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	**9,923**	**11,232**	**12,233**

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2024 Жилийн эцсийн	2025 Жилийн эцсийн	2026 Q3
Мөнгөн хөрөнгө	8,709	12,288	3,094
Дансны авлага	40,036	45,546	73,086
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,811	375	913
Бараа материал	8,025	4,503	10,246
Урьдчилж төлсөн төлбөр	21,257	10,436	17,344
Бусад эргэлтийн хөрөнгө	2,242	1,886	3,471
Эргэлтийн хөрөнгө	**82,080**	**75,033**	**108,155**
Үндсэн хөрөнгө	4,859	13,969	13,604
Ашиглах эрх бүхий хөрөнгө	606	503	3,377
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,347	1,219	1,132
Гудвилл	3,463	3,518	3,518
Эргэлтийн бус хөрөнгө	**10,275**	**19,209**	**21,630**
Нийт хөрөнгө	**92,355**	**94,242**	**129,785**
Дансны өглөг	18,276	14,609	18,112
Урьдчилж орсон орлого	-	-	-
Богино хугацаат зээл	6,906	9,336	23,109
Бусад өглөг	12,070	5,790	13,785
Богино хугацаат өр төлбөр	**37,253**	**29,736**	**55,006**
Урт хугацаат өр төлбөр	**6,452**	**9,352**	**10,052**
Нийт өр төлбөр	**43,705**	**39,088**	**65,057**
Эздийн өмч	42,325	47,041	53,508
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	6,325	8,113	11,220
Нийт Эздийн өмч	**48,650**	**55,154**	**64,728**
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	**92,355**	**94,242**	**129,785**

***Аудитлагдаагүй тайлан**

ХАЯГ
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ
+976 7701-5454
info@monlogistics.mn
www.mlholding.mn



Image generated by AI